“ЯПОН, МОНГОЛ ОЮУТНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨДӨРЛӨГ”

2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Бүх Японы оюутны холбооны гишүүн 24 япон оюутан болон ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийн япон хэлний ангийн 1-4-р курсийн оюутнуудын төлөөлөл 14 оюутан, “Ерөнхийлөгчийн илгээлт 2100” хөтөлбөрийн 24 оюутнуудыг хамруулсан 3 дахь удаагийн хамтын ажиллагааны өдөрлөг зохион байгуулагдлаа.

Тус хамтын ажиллагааны өдөрлөг нь жил бүрийн намар зохион байгуулагддаг бөгөөд япон хэлний ангийн оюутнуудад үе тэнгийн япон оюутнуудтай танилцах, цагийг үр ашигтай өнгөрөөх, хоёр орны соёлтой танилцах, найзалж нөхөрлөх сайхан боломж олгодог билээ.

Өдөрлөгийн эхэнд ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн япон хэлний ангийн 4-р курсын оюутнууд Монгол орон, соёл, баяр ёслолын талаар товч мэдээлэл бэлтгэн танилцуулав. Япон оюутнууд өөрсдийн танилцуулга хийсний дараа япон монгол оюутнуудыг багт хуваан, чөлөөт ярилцлагын цаг гаргаж, оюутнууд харилцан танилцах, хүсэл сонирхол болон өөрсдийн орны тухай дэлгэрүүлэн танилцуулах, ярилцах зэргээр цагийг өнгөрөөв.

Энэ жилийн өдөрлөгийг ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийг төлөөлсөн зохион байгуулагчаар Б.Ундармаа ажиллав. Япон хэлний багш нар бүгд оюутнуудын хамт үйл ажиллагаанд хамрагдав.















ШУТИС-ГХС-АСТ
Япон хэлний баг
2026.11.23